



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 7 сарын 08 өдөр

Дугаар 193

Улаанбаатар хот

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 6.8, 6.12 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Блэкстоун интернэйшнл ҮЦК” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 70,000,000 /далан сая/ төгрөгөөр нэмэгдүүлж хавсралтад заасны дагуу хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Блэкстоун интернэйшнл ҮЦК” ХХК /Б.Ганбаяр/-д үүрэг болгосугай.


3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны
2019 оны 3 дугаар сарын 08-ны
өдрийн 195-р тогтоолын хавсралт



“Блэкстоун интернэйшнл ҮЦК” ХХК-ийн хувь нийлүүлсэн
хөрөнгийн хэмжээнд оруулах өөрчлөлт

№	Хувьцаа эзэмшигчийн нэр, /Регистрийн дугаар/	Хувьцааны нэрлэсэн үнэ/₮/	Хувьцааны эхний үлдэгдэл			Өөрчлөлт		Хувьцааны эцсийн үлдэгдэл		
			Тоо ширхэг	Үнийн дүн/₮/	Эзлэх хувь /%/	Тоо ширхэг	Үнийн дүн/₮/	Тоо ширхэг	Үнийн дүн/₮/	Эзлэх хувь /%/
1	“Бат партнерс групп” ХХК /РД:5989639/	1000₮	50,000	50,000,000	100%	70,000	70,000,000	120,000	120,000,000	100%
	Нийт		50,000	50,000,000	100%	70,000	70,000,000	120,000	120,000,000	100%